



# **ХААН БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ**

(СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцаа  
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 3.10-т  
заасны дагуу)

Улаанбаатар хот

2025.04.24





Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар.....	4
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол .....	6
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал .....	10
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн .....	13
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр, дэг .....	15
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрүүдийн төслүүд.....	18
Саналын хуудасны загвар .....	22

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

# ХААН БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

ХААН Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3-р сарын 12-ны өдрийн 06 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

**Компанийн оноосон нэр:** “ХААН Банк” ХК

**Хурал болох газар:** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, Сөүлийн гудамж-25, ХААН Банкны Сөүл оффисын 1 давхар, ХААН театр

**Хурал болох өдөр, цаг:** 2025 оны 4-р сарын 24-ний өдрийн 14:00 цаг (Хуралд танхимаар оролцох хувьцаа эзэмшигч хурал эхлэхээс 1 цагийн өмнө ирж бүртгэл хийлгэнэ)

**Хурлын хэлбэр:** Хосолсон (танхим болон зайнаас)

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2025 оны 4-р сарын 4-ний өдөр

## ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

### 1. Танилцуулах асуудал:

- “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
- “ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга;
- 2024 оны чанаргүй эзэлийг холбогдох эрсдэлийн сангаас хаасан тайлангийн танилцуулга;
- “ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК-ийн “Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан”-гийн дүгнэлтийн танилцуулга.

### 2. Хэлэлцэх асуудал:

- “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлангийн танилцуулга, 2025 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах;
- “ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцэж батлах.

### • Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
2. “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
3. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлангийн танилцуулга;
4. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийн танилцуулга;
5. “ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төсөл;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;
8. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.

Хувьцаа эзэмшигч та 2025 оны 4-р сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд дараах газруудын аль нэгэнд хандан эсхүл [www.khanbank.com](http://www.khanbank.com) цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани;
- Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк цамхаг;
- Хурал зохион байгуулах комиссын утас 75153333-3221; 86588877; 99007781 цахим шуудан [investor\\_relations@khanbank.com](mailto:investor_relations@khanbank.com).

Хуралд биечлэн буюу танхимаар оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулан, эсвэл Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк цамхаг, орон нутаг дахь салбар нэгжүүдэд хандан, эсхүл цахим хэлбэрээр ХААН Банкны цахим хуудас [www.khanbank.com](http://www.khanbank.com)-оор дамжуулан өгөх ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2025 оны 4-р сарын 21-ний өдрийн 16:00 цаг байна.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3 дугаар  
сарын 12-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2-т Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг гаргана гэж заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын холбогдох зохицуулалтуудад заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.2 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасныг

ТУС ТУС үндэслэн ИЙНХҮҮ:

- ТОГТООХ НЬ:** Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 14:00 цагт (Улаанбаатар хотын цагаар)-т Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, Сөүлийн гудамж-25, Сөүл оффисын ХААН Театрт хосолсон (танхим болон зайнаас) хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн бирж болон Банкны цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Р.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн дотор үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай.



**ХААН БАНК**

6. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлыг Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
7. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №2-ын дагуу баталсугай.
8. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах Комиссын бүрэлдэхүүнийг Хавсралт №3-ын дагуу байгуулсугай.
9. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын Комиссын бүрэлдэхүүнийг Хавсралт №4-ийн дагуу байгуулсугай.
10. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдээс санал авах саналын хуудсыг Хавсралт №5-ын дагуу баталсугай.
11. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг танхим болон зайнаас буюу цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай мэдээлэл технологийн цахим шийдлийг бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах Комисст даалгасугай.
12. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 16:00 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, 15 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк Цамхаг, орон нутагт дахь салбар нэгжүүдэд цаасан болон цахим хэлбэр /www.khanbank.com/-ээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах Комисст даалгасугай.
13. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг тооллогын Комиссын дарга /Д.Дугарбаатар/-д үүрэг болгосугай.
14. **ТОГТООХ НЬ:** Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Т.Дарьбум/-д энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг даргалахыг даалгасугай.
15. **ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

**БАТЛАВ**



*Т. Дарьбум*  
Түдэв овогтой Дарьбум

*Д. Дугарбаатар*  
Даншандаа овогтой Хулан


*Харада Ясүнари*  
Харада Ясүнари

*Цагаач овогтой Баатарсайхан*  
Цагаач овогтой Баатарсайхан







  
Кисабуро Иший

  
Жон Ло

  
Амарбаясгалан овогтой Тамир

  
Ханс Аарт Йонгегаяйс

  
Батболд овогтой Амарсанаа

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ



## **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

### **1. Танилцах асуудал:**

- a. “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
- b. “ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга;
- c. 2024 оны чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хорогдуулсан тайлангийн танилцуулга;
- d. “Прайсуотерхаускуперс Аудит” ХХК-ийн Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлтийн танилцуулга.

### **2. Хэлэлцэх асуудал:**

- a. “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- b. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайлангийн танилцуулга, 2025 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах;
- c. “ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төслийг хэлэлцэж батлах.



## **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
2. “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайлангийн танилцуулга;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийн танилцуулга;
5. “ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төсөл;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудас;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;
8. Компанийн тухай хуулийн 65.6 дахь хэсэгт заасан шаардлагатай бусад баримт бичиг.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН  
БҮРЭЛДЭХҮҮН**



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС**

**Комиссын дарга:**

Ерөнхий аудитор – Д.Дугарбаатар

**Комиссын гишүүд:**

Хууль, эрх зүйн газрын захирал – Х.Содном-Иш

Төв банкны аудитын газрын захирал – М.Ууганчимэг

Мэдээлэл технологийн аудитын газрын захирал – Б.Эрболд

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Харилцагч хариуцсан захирал Б.Онон

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дөлгөөн

**Комиссын нарийн бичиг:**

ТУЗ-ийн Ажлын албаны хуулийн мэргэжилтэн – Ж.Үүрцайх

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР, ДЭГ**

ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАРИУЦАХ
13.00-14.00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Зохион байгуулах комисс
14.00-14.05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комиссын дарга Д.Дугарбаатар
14.05-14.10	Хурлын үйл ажиллагааг нээх	ТУЗ-ийн дарга Т.Дарьбум
14.10-14.15	Хурлын хөтөлбөрийг танилцуулах	ТУЗ-ийн дарга Т.Дарьбум
14.15-14.30	Банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах	Гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа
14.30-14.50	Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн танилцуулга хийх	“ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК
14.50-15.00	ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан болон 2025 оны зардлын төсвийн танилцуулга хийх	ТУЗ-ийн НБД В.Янжинлхам
15.00-15.10	“ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төслийг танилцуулах	Гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа
15.10-15.15	Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй тайлбарлах	Тооллогын комиссын дарга Д.Дугарбаатар
15:15-15:35	Хэлэлцэх асуудлаар асуулт, хариулт, санал	Асуулт 2 минут, Хариулт 2 минут
15.35-15.37	Банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах эсэх санал хураах	ТУЗ-ийн дарга Т.Дарьбум
15.37-15.40	ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах эсэх санал хураах	ТУЗ-ийн дарга Т.Дарьбум
15.40-15.43	“ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төслийг батлах эсэх санал хураах	ТУЗ-ийн дарга Т.Дарьбум
15.43-16.00	Завсарлага /санал тоолох/	Тооллогын комисс
16.00-16.05	Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулах	Тооллогын комиссын дарга Д.Дугарбаатар
16.05-16.10	Хурлын шийдвэрийг танилцуулж, хурлыг хаах	ТУЗ-ийн дарга Т.Дарьбум



1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах, асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахад энэхүү дэгийг баримтална.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрт заасан эрх бүхий албан тушаалтан хурлыг удирдан явуулна.
3. Хурлын ирцийг Тооллогын комисс танилцуулснаар Хурлын дарга албан ёсоор хурлыг нээнэ.
4. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд тусгагдаагүй асуудлыг хэлэлцэхгүй.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тогтоосон цагийн хуваарийн дагуу явуулна.
6. Хувьцаа эзэмшигч хурлыг аливаа хэлбэрээр үймүүлэх, зориуд саатуулах, бүдүүлэг үг хэллэг ашиглан бусдыг доромжлох, бусдын нэр төрийг гутаах, гүтгэхийг хориглоно.
7. Хурлын дэгийг зөрчсөн хувьцаа эзэмшигчид эхний удаа Хурлын дарга урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан хувьцаа эзэмшигчийг Хурлын даргын зөвшөөрлөөр Зохион байгуулах комисс хурлаас гаргах арга хэмжээг авна.
8. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууссаны дараа санал хураалт явуулж, Тооллогын комисс хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг нэгтгэж, Тооллогын комиссын тогтоолыг тус комиссын дарга нь уншиж танилцуулна.
9. Хурлын дарга Тооллогын комиссын тогтоолд үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаасныг мэдэгдэнэ.

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД

**ХААН БАНКНЫ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр  
сарын 24-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах  
зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай**

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.9 дэх заалтад компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6 дахь заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал банкны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7 дахь заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дэх заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ИЙНХҮҮ:**

- ТОГТООХ НЬ:** “Прайсуотерхаускуперс Аудит” ХХК-иар баталгаажуулсан Банкны 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн авсныг үндэслэн үүгээр баталсугай.
- ТОГТООХ НЬ:** Банкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хүлээн авсныг үндэслэн үүгээр баталсугай.
- ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

**ХААН БАНКНЫ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр  
сарын 24-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах тухай**

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалтад Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.13 дахь заалтад Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.13 дахь заалтад Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ИЙНХҮҮ:**

- 1. ТОГТООХ НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

**ХААН БАНКНЫ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр  
сарын 24-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт  
оруулах шинэчилсэн төлөвлөгөөг батлах тухай**

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

**ҮНДЭСЛЭЛ:** Монгол Улсын Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байхаар заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан банк Банкны тухай хуулийн 36.1-д заасан шаардлагыг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангасан байхаар заасныг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 5 тоот тогтоолын дагуу “ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-г баталж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар санал нэгтгэйгээр шийдсэн болохыг;

**ҮНДЭСЛЭЛ:** Банкны 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ИЙНХҮҮ:**

- 1. ТОГТООХ НЬ:** “ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
- 2. ТОГТООХ НЬ:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /В.Янжинлхам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ДАРЬБУМ

## САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ  
ХУУДАС**

Компанийн нэр: “ХААН Банк” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: \_\_\_\_\_  
Хувьцаа эзэмшигчийн иргэний бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_  
Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн  
Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

“ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагт (УБ хотын цагаар) биечилсэн болон цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Д/д	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	“ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайлангийн танилцуулга, 2025 оны зардлын төсвийг батлах эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	“ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төслийг батлах эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Бүртгэсэн/Үнэт цаасны компани: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүлээж авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_

2025 оны ...-р сарын ...-ны өдөр



## ХААН БАНК

### Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү.
2. Та саналаа урьдчилсан байдлаар заасан хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6-д байрлах ХААН Банк Цамхаг, орон нутаг дахь салбар нэгжүүдэд цаасан болон цахим хэлбэр /[www.khanbank.com](http://www.khanbank.com)/-ээр дамжуулан өгөх боломжтой.
3. Хэрвээ өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх тохиолдолд таныг төлөөлөх хүндээ Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэл үйлдэн нотариатаар гэрчлүүлэх бөгөөд таны санал итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, залруулгатай, тэмдэглэгээ буруу үйлдсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.
5. Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналыг арын нүүрэнд бичих боломжтой.
6. Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй.

---

*Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комисс бөглөнө.*

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл:

---

---

---

---



**ANNUAL SHAREHOLDERS MEETING  
BALLOT PAPER**

Company name: “KHAN Bank” JSC

Shareholder’s full name: \_\_\_\_\_  
 Shareholder’s civil ID no./ Passport no. \_\_\_\_\_  
 Type of shares held: common  
 Number of shares held: \_\_\_\_\_

Annual shareholders meeting of KHAN Bank JSC shall be held in person/online on April 24, 2025 at 2:00 PM (UB Time).

No.	Agenda items	Approved	Rejected	Abstained
1.	Whether to approve the Board of Directors’ opinion on the performance and financial reports of 2024	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	Whether to approve the Board of Directors expenditure budget for 2025	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	Whether to approve the KHAN Bank JSC Action plan for changing shareholding structure and share capital amount	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Shareholder’s signature and name: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Registered by /Securities company: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Signature and name of the authorized person who received the ballot paper: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Date: ....., 2025

**Remarks/Caution:**

1. Please put the mark (✓) in the section of your choice when filling the ballot paper.
2. You can submit your vote in advance within the given deadline, either in hardcopy via brokerage company or to KHAN Bank Tower, addressed Chinggis avenue – 6, Stadium Orgil – 1, 15th khoroo, Khan-Uul district, Ulaanbaatar, or the Bank branches and units in rural areas or online at [www.khanbank.com](http://www.khanbank.com).
3. If you submit your vote via another person/representative, you need to issue a power of attorney (PoA) as per Mongolian laws and regulations to the attorney-in-fact and get the PoA notarized. Your vote shall be deemed valid with the PoA only.
4. If the ballot paper is edited, erased, corrected, or marked with an incorrect sign, it shall be deemed invalid.
5. If you have any questions or comments with regard to the agenda item, you may write down on the reverse side of the ballot paper.
6. You may not have a right to vote again once you have submitted the vote in advance.

---

*For use of the Tabulation Commission of the Shareholders meeting only.*

Whether the ballot paper is deemed valid and counted (to be underlined): Yes/No

Signature and name of Chairperson of the Tabulation Commission: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

Reason to invalidate the ballot paper:

---

---

---

---